



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

207 /207/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.12.23

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1935 он.

Япон, Манжийн цэрэг манай улсын Булан дэрсний харуулд дахин цэргийн хүчээр довтолжээ.

“ТУСГААР ТОГТНОЛ-2021” ПРАКТИК БУУДЛАГЫН ТЭМЦЭЭН ГАРААНААС ГАРЛАА



ЗХЖШ, ХХЕГ, ДЦШ, ОБЕГ, ЦЕГ, ТТХГ, ШШГЕГ, АТГ, ШШҮХ, ҮБХИС зэрэг 12 байгууллагын 140 гаруй тамирчид цэц мэргэнээ сорин өрсөлдөж байна. Тэмцээний нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцож нийт тэмцээнд орлолцогчдод амжилт хүслээ.

Тус тэмцээн нь алба хаагчдын ур чадварыг дээшлүүлэх, Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, практик буудлагаар хичээллэгч тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ буудлагын тамирчдын залуу халааг бэлтгэж цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж буй юм.

Тэмцээний дүн маргааш гарна.

Монгол Улсад Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага үүсэн байгуулагдсаны 110 жилийн ойд зориулсан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит “Тусгаар тогтнол-2021” практик буудлагын улсын аварга шалгаруулах тэмцээн өнөөдөр нээлтээ хийлээ.

Өнөөдөр маргааш хоёр өдөр зохион байгуулагдах тус тэмцээн Монголын практик буудлагын холбооны төв клубийн буудлагын талбайд зохион байгуулагдаж байна.

Тэмцээнийг БХЯ, “Практик буудлагын холбоо”, ЗХЖШ-ын томилгоот алба хаагчид зохион байгуулж байгаа бөгөөд БХЯ,



“БӨРТЭ”-ИЙН ХАМТ ОЛОН УДААХ ГАВЬЯАТАА ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



“Бөртэ” ТӨААҮТГ-ын хамт олон шинээн аж үйлдвэрийн гавьяат ажилтан Ё.Мягмарсүрэнг хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Тэрээр өнгөрсөн сарын 26-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс шагналаа гардан авсан бөгөөд өнөөдөр хамт олон нь хүлээн авч, хүндэтгэл үзүүлж буй нь энэ юм.

Ё.Мягмарсүрэн нь тус үйлдвэрт 30 гаруй жил ажилласан ахмад ажилтан юм. Тэрээр оёдолчин хүний хамгийн их ур чадвар шаардагддаг нарийн мэргэжлийн нэг болох генерал, офицер, дайчид, бусад дүрэмт хувцас хэрэглэлийн мөрдөс, таних тэмдэг, бүх төрлийн саан хэрэглэлийг хатгадаг юм. Мөн маршал

Жуковын нэрэмжит музейн үзэмрт зориулж Реминзовын хорооны 1949 оны тугийг сэргээн засварлахаас эхлээд Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдийн 100 гаруй тугийг шинээр хийж, өөрийн мэргэжилдээ 30 гаруй хүнийг сургасан “Бөртэ” үйлдвэрийн тэргүүний ажилтан аж. Түүнийг хамт олон нь алд цэнхэр хадаг мөнгөн аягай сүүтэй төрлөх үйлдвэрийнх нь үүдэнд урмын сайхан үгсийн хамт угтаж авсан юм.

Үргэлжлүүлэн тус үйлдвэр 2021 онд бусдыгаа ажил үйлсээрээ хошуучлан ажилласан тэргүүний алба хаагчдаа шагнаж урамшуулав. Тодруулбал, 2021 оны “Тэргүүний ажилчин”-аар Эсгүүрийн тасгийн оёдолчин

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-18	-37

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
37	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,851.0
EUR	3,171.0	3,242.0
CNY	444.30	447.70
RUB	37.60	39.10
JPY	24.77	25.36
KRW	2.36	2.45

ЗУРХАЙ

2021.12.23 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 19/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Сайн нөхөртэй нөхөрлөнө

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.40-17.02

Барилдлага:

Үл зохилдох

Шүтэн барилдлага:

Авахуй

Суудал:

Уул

Аргын тооллын 12 сарын 23, Бархасвадь гараг. Билгийн тооллын 19, Үнэг одтой, хөхөгчин могой өдөр. Өдрийн наран 8 цаг 40 минутад мандан, 17 цаг 03 минутад жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ алцаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр архи уух, тамхи татах, сэтгэл муутантай нөхөрлөх зэргийг цээрлэх хэрэгтэй ба хараал, жатхыг буцаах, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрээд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх зэрэг үйлд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогосод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал “Сайн нөхөртэй учирах” хэмээх сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 277,543,285

Эдгэрсэн

Нийт: 248,700,817

Нас барсан

Нийт: 5,394,117

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2.264.962 /69.6%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,161.328 /66.4%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

862.179 26,5%

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

6931 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

195

ЭДГЭРСЭН

6608

цахим шууданд

“БӨРТЭ”-ИЙН ХАМТ ОЛОН УДААХ ГАВЬЯАТАА ХҮЛЭЭН АВЧ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Г.Оюунсүрэн, Б.Баттуяа, “Чанарын аварга”-аар гүйцэтгэх тасгийн оёдолчин Г.Тэгшбаяр, “Оны тэргүүний шилдэг ажилтан”-аар бэлтгэл тогооч Б.Мөнгөтуяа, “Хөдөлмөрийн аварга”-аар Захиргаа, гүйцэтгэх тасгийн мастер Т.Энхцэцэг, “Бөртэ хүндэт өргөмжлөл”-өөр

санхүүгийн албаны эдийн засагч Ш.Нарансанчир, “Тэргүүний тасаг хамт олон”-оор оёдлын 1 дүгээр тасагтустусшалгарсан юм. Мөн тус шагнал гардуулах арга хэмжээний үеэр тус үйлдвэрийн оёдолчин Ж. Нямжаргалд таван ханатай гэр гардуулан өгсөн юм. Оёдолчин

Ж.Нямжаргал нь 0-11 насны дөрвөн хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй аж. Энэхүү үйл ажиллагаа нь тус үйлдвэрийн хувьд уламжлал болсон бөгөөд ийнхүү ажилтан алба хаагчдынхаа нийгмийн асуудалд жил бүр дэмжлэг болдог юм. Тус үйлдвэрийн

хувьд энэ онд ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн, цар тахлын хөл хорионы үеэр халдвар хамгаалалтын дэглэмийг чанд баримтлан ажиллаж үйлдвэрийн ажиллагааг доголдуулалгүй явуулсны зэрэгцээ ажилтан

алба хаагчдынхаа мэргэжил ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр олон төрлийн сургалт дамжаанд хамруулж, бие бүрэлдэхүүнийхээ ажиллаж, амрах ая тухтай орчныг бүрдүүлэх үүднээс амралтыг өрөөг тохижуулсан, хувцасны агуулахыг шинээр

ашиглалтад оруулсан, хуучин тоног төхөөрөмжөө сайжруулж, шинэ тоног төхөөрөмжийг үйлдвэртээ нэвтрүүлсэн зэрэг олон ололт амжилттайгаар хуучин оноо үдэж байгааг “Бөртэ” ТӨААТҮГ-ын ерөнхий захирал хурандаа Д.Энхтайван хэлж байлаа.

30 КИЛОМЕТРИЙН МАРШ ҮЙЛДЭЖ ТАВАН ЦЭГТ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЛЭЭ



Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Ангийн сургуулийн жилийн цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу 30 километрийн явган маршийг 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа.

30 км-ийн маршийн үед бие бүрэлдэхүүнтэй хичээлийн таван цэгээр буюу тактикийн ажиллагаа, хордсон газар орныг туулах, байр зүйн баримжаалал бүлгийн дарга нарын ажиллагаа, цувааны хамгаалалт авах, минажүүлсэн талбайд гарц гаргах ажиллагаа болон буудлагын дасгал боловсруулах цэгүүдээр хичээл сургалтыг төлөвлөн явуулсан юм.

Маршийн амралтын үед сургалт, соёл хүмүүжлийн албанаас офицер, ахлагч,

ажилтан албан хаагчдын дунд соёл хүмүүжлийн ажлуудыг явуулж эрэгтэй, эмэгтэй гранат шидэлт, сумо бөх, орс таталтын тэмцээнүүдийг зохион байгуулав.

Э р э г т э й ч ү д и й н гранат шидэлтийн төрөлд дэслэгч Г.Цэнд-Очир, ахлагч А.Энхболд, эмэгтэйчүүдийн төрөлд ахлах ахлагч У.Мөнхнаран, Т.Даваацэрэн, сумо бөхийн төрөлд ахлагч А.Энхболд, эмэгтэйчүүдэд дэд ахлагч Ш.Наранчимэг нар түрүүлсэн бол орс

таталтын тэмцээнд ахлах ахлагч А.Энхжаргал тасгийн захирагчтай авто тээвэр засварын салааны баг тэргүүлж, ахмад О.Аюурзэд захирагчтай замын ротын баг хоёрдугаар байрт шалгарч хамт олноо манлайллаа. Төлөвлөгөөний дагуу хичээл сургалт, соёл хүмүүжлийн ажил дууссаны дараа ангийн байрлал руу хөдөлгөөн үйлдэж маршийн нэгдсэн дүнг гаргал аа.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ



ХЭН “ЯГ ТҮҮН ШИГ” БАЙВ?



Зэвсэгт хүчний 353 дугаар анги

Анги энэ сарын 17-ны өдөр цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөний дагуу сургалт, соёл хүмүүжлийн

албанаас шинэ оныг угтан бие бүрэлдэхүүний авьяас чадварыг нээн хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Яг түүн шиг” хөгжөөнт шоу тэмцээнийг зохион

байгуулан явууллаа.

Тус тэмцээнд алба, салбарууд идэвхтэй оролцсон бөгөөд Зэвсэгт хүчний 324 дүгээр тусгай рот манлайллаа.

ХОШУУЧ Б.ХЭНЗЭЭ “ХҮРЭЛ” МЕДАЛЬ ХҮРТЛЭЭ

Зэвсэгт хүчний 124 дүгээр анги Монголын Үндэсний цасан зам, спортын хорооны

нэрэмжит гүйлтийн цанын улирлын нээлтийн тэмцээний 36-40 насны ангилалд тус ангийн биеийн тамирын

офицер хошууч Б.Хэнзээ “Хүрэл” медаль хүртэж гуравдугаар байрт шалгарав.

Ахмад Д.ЭРДЭНЭСУВД

